



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР ДҮГЭЭР САРЫН 31-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-12

<i>1. “Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл</i>	4-12
---	------

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 10 дугаар сарын 31-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 54 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жаргалмаа, Т.Доржханд;
Тасалсан: Г.Ганболд.

Нэг. “Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Ж.Лхагвасүрэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр “Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар үг хэлэв.

Б.Энхбаяр: “Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр Түр хорооны хянан шалгагч, шинжээч томилох асуудлуудыг хэлэлцэх учир хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулбэ.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 15 цаг 30 минутад хаалттай горимд шилжүүлэв.

16 цаг 22 минутад хуралдааныг нээлттэй горимд шилжүүлж дээрх тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 42 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “засаг”
танхим 14 цаг 54 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая аа.

Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хяналт шалгах түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье ээ.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Ганболд гишүүн ирээгүй байна. Жаргалмаа гишүүн томилолттой, Оюунчимэг гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Энхбаяр гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Ганбат гишүүн ирээгүй байна, Доржханд гишүүн томилолттой, Цогтгэрэл гишүүн ирсэн байна.

Түр хорооны хуралдаанаар 2 асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хоёр дугаарт Хянан шалгах түр хорооны хянан шалгах шинжээчийг томилох тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг та бүхэнд шинэчлэн батлахаар тараасан байгаа.

Энэ дээр эрхэм гишүүдэд тараагдсан дээр 4.1 хянан шалгах түр хорооны сонсголыг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл хангаж сонсгол зохион байгуулах товыг батлах гээд 2023 оны 12 сарын 4 гэж тавьсан байгаа. 12 сарын 4. Энэ болохоор сонсгол болохоос 7-гоос доошгүй хоногийн өмнө нөгөө товоо зарлах ёстой. Нээлттэй сонсгол хуулиараа тийм байгаа. Тэгэхээр сонсгол хамгийн багадаа 12 сарын 11-нд зарлагдахаар төлөвлөгөөний төсөл тараагдсан. Энийг бол би гишүүдэд ийм санал оруулах гэж байгаа юм. Өөрчлөөд би урьдчилсан байдлаар энэ хянан шалгах шинжээчдийг өмнөх Түр хорооны 197 Улсын Их Хурлын архивд хүлээлгэж өгсөн материалтай танилцуулж судлуулж дууссан байгаа. Томилогдсон хянан шалгах шинжээчдийг. Хянан шалгах шинжээчдийн урьдчилсан надад өгсөн танилцуулгаар нэг удаагийн сонсголоор энэ амжихгүй ээ гэдэг зүйлийг хэлж байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ хураагдсан цугларсан нотлох баримтуудын бас дийлэнх нь нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол шаардлага хангахгүй ээ гэж танилцуулж байгаа юм. Бүрдүүлбэрийн хувьд бол нэмж маш их нотлох баримтуудыг нэмж авах шаардлага байна гэдэг ийм асуудлыг танилцуулж байгаа. Ямар ч байсан Улсын Их Хурлын тогтоолын үүрэг бол

энэ намрын чуулганд багтааж Түр хороо сонсголоо хийгээд тайлангаа тавих ёстой.

Тэгэхээр намрын чуулган бол он гараад 2024 оны 1 сард дуусгах ёстой. Тэгэхээр түр хороо нээлттэй сонсголоо хийсний дараа тайлангаа гаргана. Улсын Их Хуралд танилцуулна гээд бас нэлээн нөгөө юунууд гардаг, хугацаа гардаг. Тийм учраас энэ цаг хугацааны нөхцөл байдлыг тооцож үзвэл Түр хорооны сонсголыг 2 хуваагаад ийм өдөр хийх боломжтой байна гэдэг хуваарийг эхлээд хэлэх гэж байгаа юм. 2023 оны 12 сарын 4-8 ажлын 5 хоног.

Хоёр дахь сонсголыг 2023 оны 12 сарын 18- 22 гэсэн.

Нийт 2 хувааж дундаа 7 хоногийн завсартай дараагийн сонсголд бэлдэх ийм бэлтгэл ажлын 7 хоногийн хугацаатай. Тэгээд явахад үндсэндээ бидэнд эхний сонсголыг хийхэд ганцхан сарын хугацаа байна гэсэн үг. Энэ бол маш их шахуу ийм нөхцөл байдал байна. Тийм учраас би энэ 2 дахь асуудал дээр хянан шалгах шинжээч дээр нэлээн 8-аас 9 хүнийг томилуулахаар та бүхэнд санал болгоно. Яагаад гэхээр одоо байгаа хүчээр ямар ч боломжгүй байгаа ийм цаг хугацаанд.

Тийм учраас та бүхэн маань энэ тов зарлах гэдэг энэ хугацаа бол өөрчлөгдөх нь байна. Хэрвээ 12 сарын 4-нд бид эхний сонсголоо хийвэл энэнээс 7 хоногийн өмнө товоо зарлах ёстой болно гэсэн үг. Тийм учраас энэ тов нь өөрөө 7 7 хоногоор урагшаа гүйх нь ээ. Энэтэй холбоотойгоор тэр гэрч дуудах, мэдэгдэх хуудас хүргүүлэх, сонсгол зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах гэсэн энэ хугацаануудад бол ингээж наашаа цаашаа ийм хоногуудын өөрчлөлт гарах нь байна шүү гэдгийг та бүхэн маань ойлгоод энэ төлөвлөгөөг тэгж ойлгож баталбал ямар вэ гэж. Тэгээд үнэхээр энэ хянан шалгагчид бид нар энэ хянан шалгагчдыг ингээд өнөөдөр

томиллоо гэхэд энэ чинь нэг сар бас ажиллана, юу болох нь байна.

Тэгээд та бүхэн маань санал юмаа хэлээд тэгээд энэ төлөвлөгөөг ингээд баталчихвал яаж байна вэ гэж ийм зүйлийг хэлэх гэж байгаа юм. Энэ дээр бол тэр газар дээр нь бас түр хорооны гишүүд бас очиж танилцах гэсэн ийм ажлууд бас бичсэн байгаа юм. Та бүхэн бас энэ дээр өөрсдийнхөө цаг хугацааны боломж нөхцөл юмнуудаа бас хэлээд энийг нь өдрүүдийг нь дандаа онгорхой орхиод байгаа юм. Төлөвлөхөд их хэцүү байгаад байна. Тийм учраас энийг нь та бүхний саналыг авч байгаад ингээд Түр хороон дарга баталгаажуулбал ямар вэ гээд онгорхой орхиод та бүхэнд тараасан байгаа шүү. Баярлалаа.

Ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа.

Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Ойлгомжтой энэ дээр үр дүн л гарах ёстой. Хамгийн гол нь Монголын ард иргэд нүүрсний олон их наядын хулгай юу болов яв гэдгийг харж байгаа. Энэ Засгийн газрын бас гаргаж ирж энийг нь бас нэг үр дүн гаргачих санаатай би зүгээр нэг хорьцоод л тавьдаг. Эсвэл ингээд нэг гаргаж ирчхээд чимээгүй болдог улсууд биш ээ. Улсын Их Хурал бол хяналт шалгалт хуулийн хэрэгжилт дээрээ анхаараад эхэлчихсэн гэдэг энэ том дохио. Тэгээд энэ утгаараа үр дүн л гарах ёстой. Энэ товын тал дээр ажил хэргийн үүднээс энийг бол дэмжээд явна аа. Гол хэлэх гээд байгаа зүйл юу вэ гэвэл өмнө нь Гочоогийн Ганболд гишүүн ахлаад явж байхад би их идэвхтэй ажиллаж байсан. 8 удаа хуралдсан санагдаад байх юм. Тэр хурал болгон дээр би оролцож ажиллаж байсан.

Шинжээчид байдаг тэнхээгээрээ л ажилласан тэр шинжээчид. Тэгэхлээр тэндээс бол одоо нэг л монгол юм чинь дээ. Энд байгаа шинжээчид тэнд ажилласан эксперт шинжээчидтэй уулзаж ярьж бас материалуудтай нь танилцаж судалж бүгдийг нолиос эхлэх биш тэд нараас бас авах юмнуудаа сайн авч өөрийн болгож чадсан уу? Энэ асар их хугацаа хэмнэнэ. Асар их бас тэнд чинь миний мэдэхийн бүтэн нэг жил хөдөлмөрлөсөн. 6, 6 сараар ингээд 2 удаа ажилласан гэдэг утгаараа тэнд байгаа зүйлүүдийг манай ажлын хэсэг, шинжээч энэ шинэ, нүүрсний 2 дугаар Түр хороо үр дүнг нь үзэж өөртөө шингээж авсан уу гэдэг асуултыг асууя?

Б.Энхбаяр: *Одоо ийм байгаа юм.*

Нэгдүгээрт архивт байгаа 200 нэгж материал дотор өмнөх Түр хорооны ажилласан шинжээчийн дүгнэлт нь нийтдээ 40 хуудас шинжээчийн дүгнэлт байна гэж байгаа. Тэгэхдээ тэр нь ямар ч гарын үсгээр баталгаажсаагүй, нэгдсэн шинжээчийн дүгнэлт гараагүй ийм материал архивт байна гэдэг зүйлийг танилцуулсан.

Өөрөөр хэлбэл нотлох баримтын шаардлага хангахгүй байна гэж.

Хоёрдугаарт ер нь би яах вэ өмнөх төрийн залгамж халаа мэдээж байгаа ажиллана. Гэхдээ тэр дотор сонирхлын зөрчилтэй шинжээч нар ажилласан байна гэж ерөөсөө үзэж байгаа юм. Тухайлбал яг энэ нүүрсний хэрэгт шалгагдаж байгаа Улсын Их Хурлын гишүүний туслахаар ажиллаж байсан 4 жил. Цагаан хаданд гүйцэтгэх захирлаар 3 жил ажиллаж байсан хүн энэ Улсын Их Хурлын Нүүрсний түр хороонд шинжээчээр ажилласан байна. Сонирхлын зөрчилтэй. Өөрийг нь шалгах ёстой байсан чинь өөрөө шалгаад явчихсан байна.

Тийм учраас энэ асуудал дээр шинжээчдийн хараат бус байдлыг хангах

мэргэшсэн байдлыг хангах чиглэлээр илүү өргөтгөөд Үндэсний аудитын газраас 2 хүн, Монголбанкнаас 4 хүн, тэр дотроо нүүрсний асуудал нь хил дамнасан байдалтай нийт худалдан авах ажиллагаанаас гарсан гүйлгээний 70 хувь нь гадаад улс руу шилжсэн байна гэж байгаа. Энийг бол гадаад улс руу шилжсэн мөнгөн гүйлгээг цаашид хянан шалгах эрх бүхий тусгай эрхтэй улсын байцаагч л байдаг Монголбанкнаас дээр. Тэр нь бол ерөөсөө хоёрхон хүн байдаг. Гадагшаа шилжсэн. Тэгэхээр тэр гадаад гүйлгээний цааши нь хөөх шаардлага үүсэж байгаа учраас тэрийг эрхтэй тийм хүнийг бас татан оруулах шаардлага үүсэж байна. Мөн яг төрийн худалдан авах үйл ажиллагаан дээр хийгдсэн шалгалтын асуудал байхгүй байна. Худалдан авах ажиллагаа энэ чинь нэл нэлээн олон их наядын асуудал яригдаж байна. Тийм учраас төрийн худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн 2 хүн бас нэмж татна шаардлага үүсэж байна гэх мэтээр нотлох баримтыг шинжлэн судлах хэмжээний сонсгол хийх гэхэд шаардлагатай тийм хэмжээнд нотлох баримт байхгүй байна гэж надад танилцуулсан.

Тийм учраас энэ ерөнхий төлөвлөгөөг шинэчилж батлаад хэдий богино хугацаанд байгаа ч гэсэн энэ ерөнхий төлөвлөгөөний дагуу ёстой үзнэ дээ.

Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: *Нүүрсний түр хороо сонсгол дээр шинжээч нэмж томилуулах асуудал яригдаж байгаа юм байна. Үнэхээр зөв өө. Энэ шинжээч томилогдох ёстой. Хянан шалгах чинь томилогдох ёстой. Энэний хүрээнд хангалттай материал цуглуулж олон нийтэд энэ мэдээллийг сайн хүргэх ёстой. Би бас яагаад энийг хэлж байна вэ гэхээр би ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үйл явцыг хариуцаад энэ 40 их наядын асуудал яригдаж байгаа*

бол энэ 40 их наяд чинь харин ч бараг жаахан сансрын тоо явж байгаа.

Тэр ковид дээр хориод их наядын асуудлыг ярихад нэг ч шинжээчгүй, нэг ч хянан шалгагч үгүй сонсгол явуулах ийм нөхцөл байдалд ороод энэний бас бэрхшээлийг үзээд явж байгаа хүний хувьд энийг дэмжиж байна. Гол нь энэн дээр би энэ ажлын төлөвлөгөөг ингээд харахад ерөнхий нэр яваад байна л даа. Энэ нүүрсний сонсголоор яг ямар асуудлуудын цар хүрээг ярих гэж байгаа билээ. Яг энэ энэ сэдвүүдээр яригдана гэдгийг хаанаа хэзээгээ ярих юм. Асуудлын цар хүрээгээ. Ингээд нэг сонгож авчихсан хэдэн сэдэв дээр нөгөө шинжээчид нь бид нарын энэ байгаа материалын хүрээнд ажилласан дүгнэлт юм байна гээд аваад ирэхээр энэний хүрээнд сонсгол болох юм уу, энэний хүрээнд гэрчийг дуудах юм уу? Харин эхлээд цар хүрээгээ тогтоод тэр Эрдэнэс Тавантолгойн бүлэг орд энэнтэй холбоотой энэ энэ асуудлууд бүгдээрээ багтана гэдэг энэ задаргаа манай энэ ажлын төлөвлөгөөн дээр харагдаж өгөхгүй байгаад байгаа юм. Таны өөрийн чинь хэлж байгаагаар болохоор ирсэн материалыг шинжлээд тэрэн дээр санал гаргаад тэрийг бид нар тойрчихъё. Сонсголын өдөр энэний хүрээнд гэрчээр дуудах уу?

Тэгэхээр энэ гэдэг нь хэрвээ ингэж явбал нөгөө нэг ард иргэдийн мэдэхийг хүсээд байгаа олон нийтэд эргэлзээтэй байгаа олон асуудлуудынхаа тэр эргэлзээг хэрхэн яаж тайлах вэ? Энэн дээр дунд нь санаатай санаагүйгээр зарим асуудлууд сугарч үлдэх юм биш биз дээ гэдэг бас нэг ийм хардлага гэх үү, санал гэх үү байна л даа. Тэгээд энэн дээр та нэг гол нь энэ ажлын цар хүрээнд дээр яаж бид нар тогтоож энийг ярих вэ гэдэг дээр та нэг хариулт өгөөч.

Б.Энхбаяр: Түр хорооны хяналт шалгалтын цар хүрээ нь өөрөө Улсын Их Хурлын түр хороо байгуулах тогтоол дээрээ тодорхой заагдсан байгаа. Тэр нь

бол төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компани гэдэг нь бол Эрдэнэс Тавантолгой компани, жижиг Тавантолгой компани. Энэ 2 компанийг хэлж байгаа юм. Нүүрс олборлолт, тээвэрлэлт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.

Энэ нь юу хэлж байна вэ гэхээр энэ 2 компанийн байгуулагдсанаас эхлээд шалгагдах өдрийн байдлаар хүртэл бүх үйл он дарааллаар үзнэ гэсэн үг. Тэгэхээр энэ өөрөө 10 гаруй жилийн асуудлыг үзнэ. Өмнөх Түр хорооны шалгагдаж байгаа материалыг үзэхэд ч манай шинжээч нарын танилцуулснаар бол онууд нь тасраад байна гээд байгаа юм. Цугларсан материал нь. Жишээлбэл хилээр гарсан машинтай холбоотой асуудал гэхэд 2013-аас 2017 он. Зөвхөн ингээд 4 жил. Тэгтэл өмнөх нь хаачсан юм. Тэр нь 2017 оноос хойших нь хаачсан юм бас байхгүй. Гаалийн мэдүүлэг зөрж байгаа асуудал нь гэнгүүт 2017 оноос хойш ч гэдэг юм уу. Гэтэл 2013 онд энэ асуудал үүсээд хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байсан асуудал байдаг. Тэр асуудал яагаад энд орж ирэхгүй орхигдчихов.

Энэ материалд байхгүй байна гэдэг асуудал гарч ирээд байгаа байхгүй юу. Тийм учраас миний түрүүний хэлсэнчлэн энэ нотлох баримтуудыг бүтэн зургаар нь бүрэн зураглалаар харахын тулд анх он байгуулагдсанаас нь эхлээд өнөөдрийг хүртэлх бүх нүүрс тээвэрлэлт, компанийн үйл ажиллагаа, бүх борлуулалт, тээвэрлэлт, экспорт, худалдан авах ажиллагаа бүгдийг нь бүхэлд нь бүрэн зураглалаар нь үзэж байж энэ асуудал сая иргэдийн мэдэх эрхийг хангана.

Тийм ч агуулгаар сонсголын үйл ажиллагааг нэг удаа хийх боломжгүй байна гэж урьдчилсан байдлаар үзэж байгаа. Өөрөөр хэлбэл 2 удаа хувааж

саяын багц асуудлыг 2 удаа хувааж авч үзэхгүйгээр огт багтахгүй юм байна. Агуулга цар хүрээний хувьд гэдэг ийм байдлаар төлөвлөгөөний төслийг бас боловсруулж та бүхэнд танилцуулж байна аа.

Цогтгэрэл гишүүн нэмж асууя.

О.Цогтгэрэл: Тийм ээ тэгэхээр цар хүрээ болохоор ийм маш өргөн. Гол нь энэ өргөн цар хүрээн дотроос цаг хугацаа болоод олон зүйл шинжээчийн дүгнэлт, хянан шалгалтын материал, хянан шалгагчийн материалд үндэслээд тодорхой зорилго бүхий зарим нь сугараад үлдчих вий. Тэгэхээр энэ цар хүрээний жагсаалтыг бид нар хэзээ батлах ёстой вэ? Би гол нь эхлээд энэ энэ асуудлууд үлдэхгүй байх ёстой гэдэг энэ жагсаалт дээрээ бид нар эхлээд тохирох ёстой л санагдаад байна л даа. Энд яг энэ төлөвлөгөөгөөр болохоор дандаа ингээд ерөнхий нэрээр яваад байгаа байхгүй юу. Яг сая таны хэлдэг Их Хурлын тогтоол дээр байгаа тэр ерөнхий нэрээр л юм яваад байгаа юм. Тэгээд сүүлд нь нэг өдөр сонсголд орж ирээд суусан чинь нөгөө олон нийтийн хардаад сэрдээд байдаг олон асуудал чинь энэ дотор байхгүй сугараад үлдчихсэн байх вий гэдгээс энэ ажлын хэсэг болоод түр хороо хэзээ нь энийгээ тогтоож авах ёстой вэ энэ тэр сугарахгүй байх нөхцөл бололцоог яаж хангах вэ л гэж асуугаад байна л даа.

Б.Энхбаяр: Саяын хэлсэн хүрээнд одоо юм орхигдчих вий, сугарчих вий гэдэг яг энэ агуулгаар л хянан шалгагч, шинжээч нартаа үүрэг өгөх гээд байгаа юм. Томилоод.

Тэгээд одоо энэ чинь та бид ч тэр ингээд бас л урьдчилаад үзчихсэн хүн байхгүй байгаад байна шүү дээ. Бүтэн зургаар нь бас. Тэгэхээр урьдчилаад энэ нь үлдчихэж байгаа юм уу, үлдэх гэж байгаа юм уу гэдгээ одоо бид нар бас харанхуйд хааж хэлж чадахгүй байгаад байгаа юм. Зарчмын хувьд бол энэ 2

компанийн анх байгуулагдсанаас эхлээд л сая бүх асуудлыг үзэж аливаа юм орчихгүйгээр нэгтгэж юм үзүүлэх чиглэлийг л бид Хянан шалгагч, шинжээч нартаа л өнөөдөр өгөх гээд байгаа юм. Ерөөсөө гол агуулга нь. Одоо болохоор урьдчилаад би танд ч энэ нь байгаа тэр нь байгаа гэж. Би бас энэ чинь хянан шалгагч нар чинь ажил эхлээгүй байгаад байгаа байхгүй юу. Ингээд томилохоор тийм л асуудал байгаад байгаа юм.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүн үг хэлье.

Ж.Сүхбаатар: Үгүй ээ яах вэ би бол энэ Цогтгэрэл гишүүн, Ганбаатар гишүүн 2 байж байна. Ялангуяа Цогтгэрэл гишүүнд хандаж хэлэх гэж байгаа энэ Энхбаяр дарга ч гэсэн бас анхаар. Нөгөө улс төр хийхийн тулд л манайхан чинь хийгээд байдаг юм шүү дээ. Тэгэхээр энэ Цогтгэрэл гишүүнийхээ хэлээд байгаа юман дээр идэвхтэй анхнаас нь оролцуулах боломжийг нь хангаарай. Тэгээд нөгөө дараа нь нөгөө гишүүдийнхээ шахалтад ороод би ч тэрэнд нь ороогүй эд нар ч ингэсэн гээд байж болохгүй. Тэгээд ер нь Нүүрсний сонсгол нэг их нам замын эрх барьж байгаа улсууд хамгаалах гэж байгаа юм юу ч байхгүй учраас олон нийтийн мэдээллээр хангах гэж байгаа асуудал учраас тэр мэдээлэл бусад юмыг нь би илүү нөхцөлөөр энэ ялангуяа цөөнхийн энэ бүлгийнхээ нөхдүүдийг илүү хангах нь зөв байх шүү.

Түр хорооны дарга өөрөө сайд учраас бас олон ажилтай. Гэхдээ бас энэ цөөнхийн санаа бодлыг тэр хүндэтгэж хүлээж авах талаас нь анхнаас нь нэг их тийм сайн хандаж ажиллаарай. Тэгэхгүй бол дараа нь бие биетэйгээ ингээд юм ярьдаг. Ер нь энэ нүүрсний иргэд чинь тэгээд л олон янзын л намын улсууд орооцолдчихсон л явж байгаа шүү дээ. Хэдэн их наядаар нь зарим нь яриад л бүүр барин тавин яриад л байгаа. Ер нь

бол Монголын баялгийн олон юм хулгайлагдсан гэдэг нь ойлгомжтой байгаа шүү дээ. Одоо олон талаар бид нарын авч байгаа мэдээллээр. Хил гааль нь ч яачихсан газар байдаг юм. Тэгээд сүлжээ ингээд л тэр өмнө нь миний энэ ажиллаж үзсэн нийтийн тээврийн салбар гэхэд би заримыг нь сая л ойлгож байна. Ухаад л захаас нь үзэхэд л тэгээд л зөндөө юм байдаг. Гэтэл энэ нүүрс чинь бас ингээд нэг олон арван хэчнээн ч олон этгээд оролцсон байдаг юм.

Ингээд л аваад үзвэл төрийн, төрийн бус тэгээд л энэний мөнгө нь хаашаа ч орчихдог юм. Тэгээд энэ бол их тийм маш том асуудлууд учраас би бол энд Цогоо гишүүн Ганбаатар гишүүн ч байж байна. Ер нь бичгээр заримыг нь бас саналыг нь авах хэрэгтэй л дээ. Ер нь тэгээд бичгээр ер нь зарим юмнуудаа хэлээд яг тийм бичгээр харилцаж байх нь бас зөв байх шүү. Зарим асуудлуудыг явал амаар өгөхөөс гадна бичгээр тэрийг нь баталгаажуулж аваад тэгээд ингээд явбал би бас ажилд тустай юм уу? Одоо бол дуу хоолойгоо бүгд л өргөх цаг л даа. Хэдэн жилийн дараа түр хороонд ажиллаж байсан гэдэг. Энэ нүүрсний асуудал бол Монголд нэг ойрын 10 жилдээ нүүрсээ гаргасаар л байх болно. Нэлээд асуудал.

Тэгэхээр энэ нүүрсний хэрэг маргаан бол сонсгол дуусахад бас дуусахгүй байх. Тэгээд л энэ яриа үргэлжлэх учраас би тэр баримт бичгийн хэлбэр дээр илүү их анхаарч түшиглээрэй л гэж хэлэх гэсэн юм.

Б.Энхбаяр: Гишүүдийн хэлж байгаа саналыг, оролцоог хангаж ажиллана аа. Тэгэхдээ томилогдож байгаа хянан шалгагч, шинжээч нарын хараат бус байдлыг их хангаж ажиллана. Урьд нь бас Хөгжлийн банкны сонсгол хийх дээр бас түр хорооны гишүүдээ хянан шалгагч нарыг ийм юм үзье. Тэрний тэр гишүүнийг нэг ухаадхаач энэ тэр гээд. Энэ чинь бүүр

улс төр нэг тойргийн гишүүдээ ухуулах гэсэн ийм асуудлууд бас гарч байсан.

Тийм учраас би бол энэ улс төрийн зүй бус нөлөөлөл. Энийг аягүй их сайн хангаж ингэж ажиллана. Угаасаа нөгөө Хяналт шалгалтын тухай хуульд зааснаар бид нар чинь 7 хоногийн өмнө сонсголынхоо товьыг зарлана шүү дээ. Яг энэ тов зарлахтай хамт ямар сэдвээр, ямар асуудлаар нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол хийх вэ? Ямар хугацаатай хийх вэ хэнийг гэрчээр дуудах вэ гэдэг яг 7 хоногийн өмнө хуралдаан хийнэ. Яг энүүгээрээ бол бүгдийг нь ер нь эцэслэн батална. Яг энэ үед бол Цогтгэрэл гишүүний хэлээд байгаа ерөнхий баримжаа бол гарсан байна.

Ерөнхий баримжаа тодорхой гарсан байх байх гэж бодож байна. Яагаад гэхээр энэ чинь ямар асуудлаар сонсгол хийх гэж байна вэ? Хэнийг дуудах гэж байна вэ гэдэг асуудал яригдана гэдэг чинь ер нь нэг баримжаа урьдчилсан байдлаар гарсан байх үе нь бол 11 сарын сүүл л болж таараад байх шиг байгаа юм. Яг сарын дараа гэж хэлэх байна.

Тэгээд бас урьдчилсан хатуу би бол бас яг амлалт өгч чадахгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр ингээд хэт богино хугацаагаар шахаад дутуу хийчихмээргүй байгаад байгаа юм бас. Нөгөө бушуу туулай борвиндоо баастай болчихмооргүй байгаад байгаа юм. Тийм ээ бид нарыг хурдан хийгээд байна уу эсвэл бүх асуудлыг бодитойгоор тэр мэдэх эрхийг хангах гээд байна уу?

Тэгэхээр асуудлын цар хүрээ маань их өргөн, хугацаа их давчуу нөхцөл байгаа гэдгийг эрхэм гишүүд маань ч тэр иргэд олон нийтэд маань ч гэсэн ойлгож үзэх байх гэж ингэж бодож байна. Мэдээж бид цаг наргүй ингэж ажиллаж таарна. Миний хувьд бол бараг чөлөөт цагаараа Хууль зүйн сайдынхаа ажлыг хийх байх. Түр хороон дарга дээрээ

төвлөрч ажиллана. Би 11 сард гардаж ажиллана, имэрч ажиллана.

Тийм учраас би энэ нүүрсний асуудал дээр онцгой анхаарна. Монгол Улсын Ерөнхий сайд ч гэсэн Хууль зүйн сайдаар санал болгох үед энэ асуудлыг нүүрсний энэ асуудлыг иргэд олон нийтийн мэдэх эрхийг хангаж бүх асуудлыг иргэд олон түмэнд нээлттэйгээр иж бүрнээр нь шалгаж илчлэхийг үүрэг болгосон.

Тийм учраас энэ үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж онцгой анхаарч л ажиллана даа. Цаг нар бүх юмаа бүгдийг энд зарцуулна гэсэн ийм бодолтой байгаа шүү гишүүд ээ.

Ингээд гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Саналын томъёолол тогтоолын хаана байна.

Саналын томъёолол наана чинь байхгүй байна. Энд саналын томъёолол байна.

Хянан шалгах түр хорооны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 66.7 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Хоёр дахь асуудалдаа орё.

Хянан шалгагч шинжээчээр томилох тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн хянан шалгагч, шинжээч нарын асуудлыг хаалттай горимоор шийдэх горимын саналыг дэмжье гэдэг саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт 66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

Хуралдааныг нээлттэй горимд шилжүүлъя.

Хуралдаан нээлттэй горимд шилжсэн байна.

Их Хурлын Хянан шалгах хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хийх ажлын ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах Түр хороонд даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хянан шалгах түр хорооны 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүй болсон тооцсугай.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулттай гишүүн байна уу? Ганбат гишүүнээр тасаллаа.

Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд нүүрсний түр хороо маань нэлээн хүлээлт үүсгээд байгаа ийм түр хороо. Тэгээд бид бүхний ажлыг бас ингээд нийгэм даяараа харж байна аа. Тэгээд гадна дотнын янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалаад бид бүхэн бараг зохион байгуулалтын асуудлыг 2, 3 дахиа ярьсаар байгаад л ингээд л өнөөдрийг хүрчихлээ.

Тэгээд төлөвлөгөө тогтоолоо баталж байна. Энэ яг хийх ёстой ажлууд ингээд хойшлогдоод байна аа. 9 сард төлөвлөсөн ажил маань ингээд 10 сард төлөвлөсөн ажил маань ингээд 9 сар, 10 сар ингээд дуусчихлаа. Энэ чинь 9 сараас эхлээд ингээд 4, 5, 6 сар хийх ёстой ажил маань ингээд 1, 2 сард ингээд болчихоод байна.

Тэгэхээр амжих уу яах вэ гэдгийг бас яаж ч шахуу ажиллаад бид нар чинь улсын төсвөө ярьж байна тэгээд энэ чинь 15-наас наашгүй. Тэгээд 12 сар гээд хүйтэрчихнэ. Тэгээд шинжээчид маань дөнгөж зарим нь өнөөдөр ажилдаа орох гэж байна гэсэн ийм асуудлууд байна.

Энэ дээр яаж хандвал зүгээр вэ? Энэ төлөвлөгөө маань яг биелэхээр байна уу? Хэрвээ энэ төлөвлөгөө биелүүлж байж л чанартай ийм сонсгол болох байх л даа ард иргэддээ мэдээлэл өгсөн.

Б.Энхбаяр: Яг 1 сарын өмнө Хянан шалгах түр хороонд 5 хянан шалгагч томилсон үүнээс 3 хянан шалгагч нь өөрсдийн хүсэлтээр чөлөөлөгдсөн чөлөөлөгдөж байна. Ямар учир шалтгаантайг бол өөрсдөөс нь асуух боломж гарсангүйгээр өргөдлөө өгчхөөд алга болчихлоо. Сая бид чөлөөллөө.

Үүнтэй холбоотойгоор Ганбат гишүүн ч зарчмын асуулт асууж байна. Бид намрын чуулганд багтааж тайлангаа тавих ёстой.

Намрын чуулган нэг сард дуусна он гараад. Тэгэхээр бид энэ ондоо багтааж нотлох баримтыг шинжлэн судлах сонсголоо хийх учиртай.

Цаг туйлын шахуу байгаа гэдгийг бид хаа хаанаа хэн бүхэн ойлгож байгаа.

Тийм учраас өнөөдрийн Хянан шалгах түр хороогоор нэмж өмнө нь нэмсэн 3, дахиад өнөөдөр 7, нийтдээ 12 хянан шалгах шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр өнөөдөр бид хянан шалгах үйл ажиллагаа руу орох гэж байна аа. Хугацаа богино байна.

Бидний үзэж байгаагаар нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2 үе шаттай хийхээр урьдчилсан таамаг гарч ирж байна.

7 хоногийн дундаа завсарлагатайгаар 12 сард, 2 удаагийн сонсгол хийх шахуу төлөвлөгөөг бид баталж байна.

Ингэснээр үндсэндээ 1 сарын хугацаанд энэ шалгалтын ажил саяын хэлсэн 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр өнөөдрөөс эхэлнэ.

Хугацаа маш богино байгаа. Тэгэхдээ бушуу туулай болох ёсгүй.

Баримт материалууд нэлээн их асуудал байгаа. Хууль хяналтын байгууллагаар эхнээсээ бас шүүх хурал нь болж байгаа асуудал үүсэж байна.

Тийм учраас бол энэ дээр богино хугацаанд иргэдийн мэдэх эрхийг хангасан хүрээнд хяналт шалгалтыг хийнэ. Мэдээж тухайн компанийг байгуулагдсан цагаас өнөөдрийг хүртэлх хугацаан дахь бүх л асуудлыг хянан шалгаж шинжээчийн дүгнэлтээ гаргахыг

*холбогдох шинжээч нартаа үүрэг
болгож ажиллана аа.*

*Тогтоолын төслөө баталъя.
Гишүүд асуулт асууж дууслаа.*

*Тогтоолын төслийг баталъя гэдэг
саналын томъёоллоор санал хураалт
явуулъя.*

Санал хураалт.

*71.4 хувийн саналаар тогтоол
батлагдлаа.*

*Өнөөдрийн түр хорооны
хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан
тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

16.28 цаг

Бичлэгээс буулгасан:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА**